“СУРГУУЛЬ ХООРОНДЫН ЯПОН ХЭЛНИЙ УРАН ИЛТГЭЛИЙН ТЭМЦЭЭН”

2026 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Японы ЭСЯ, Монголын япон хэлний багш нарын холбоо, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, ШУТИС-ийн Гадаад хэлний сургуулийн Ази судлалын тэнхим болон Япон сан хамтран “Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 32 дахь тэмцээн”-ээ амжилттай зохион явууллаа.

Уран илтгэлийн тэмцээний их дээд сургуулийн ангилалд 34 оюутан бүртгүүлснээс эцсийн шатанд шалгарсан 10 оюутан “私が作りたい未来での「当たり前」” сэдвээр, ахлах ангийн сурагчдын ангилалд 38 сурагч бүртгүүлснээс эцсийн шатанд 10 сурагч шалгарч, “新しい「スキル」がもらえるなら” сэдвээр тус тус япон хэлээр уран илтгэх чадвар, япон хэлний мэдлэгээ сорин оролцлоо.

Ангилал тус бүрд 1-3 дугаар байр, тусгай байр эзэлсэн оюутан сурагчид өргөмжлөл, их дээд сургуулийн ангилалд 1,2 байр эзэлсэн оюутнууд Япон сангийн сургалтад хамрагдах эрх, ангилал тус бүрийн шилдгүүд Японы Засгийн газрын JENESYS хөтөлбөрөөр Япон улсад аялах эрхээр шагнуулав. Мөн эцсийн шатанд шалгарсан бүх оюутан сурагчдад Монголын япон хэлний багш нарын холбоо, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, ШУТИС-ийн Гадаад хэлний сургуулийн Ази судлалын тэнхим болон Япон сангийн гарын бэлэг гардуулав.

Тус тэмцээний эцсийн шатны шалгаруулалт Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвд болсон ба Монгол дахь япон иргэдийн холбоо, Японы худалдааны танхим ивээн тэтгэлээ.

Тэмцээний их дээд сургуулийн ангилад ШУТИС-ийг төлөөлж Гадаад хэлний сургуулийн 2-р курсийн оюутан Г.Амаржаргал, ахлах ангийн сурагчдын ангилалд ШУТИС-ийн харъяа Технологийн коллежийн 3-р курсийн оюутан О.Энхдөл нар эцсийн шатанд шалгарч, япон хэлээр илтгэл тавьж, амжилттай оролцлоо.

Энэ жилийн тэмцээний ШУТИС-ийн Гадаад хэлний сургуулийн Ази судлалын тэнхимийг төлөөлсөн зохион байгуулагчаар Л.Сарангэрэл, Б.Ундармаа нар ажиллав. Оюутан Г.Амаржаргалыг Э.Сайнбилэг багш удирдан оролцууллаа.









ШУТИС-ГХС-АСТ
Япон хэлний баг
2026.11.23